



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 8-512

Улаанбаатар хот

Уулзалтад оролцуулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Б.Гантуяа, Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Санхүүгийн мэдээллийн албаны дарга Х.Батчулуун, тус албаны дэд дарга Т.Дуламсүрэн, тус албаны ахлах хянан шалгагч Л.Очгэрэл, Хяналт шалгалтын газрын Тусгай хяналтын албаны ахлах хянан шалгагч Г.Даваахүү нарыг Тайландын Вант Улсын Бангкок хотноо 2019 оны 9 дүгээр сарын 07-ноос 14-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Ази Номхон далайн хамтарсан бүлгийн хуралд оролцуулсугай.

2.Дээрх нэр бүхий ажилтнуудын томилолт, унааны зардлыг батлагдсан төсвийн дагуу урьдчилгаагаар олгож, баримтыг нь үндэслэн Тамгын газар, Хууль, эрх зүйн газар, Санхүүгийн мэдээллийн алба, Хяналт шалгалтын газрын гадаад томилолтын зардлаас гаргахыг Тамгын газар (Ж.Батхуяг), Тайлан бүртгэлийн газар (Ц.Гарьд)-т тус тус зөвшөөрсүгэй.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН